



2025 он 05 сар 14 өдөр

Дугаар 19

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг сонгох тухай

Говь ХК-ийн 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг шинээр сонгон томилсонтой холбогдуулан, Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг сонгох тухай асуудлыг хэлэлцсэний үндсэн дээр Компанийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1 заалт, Компанийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.2.17 дугаар заалтыг тус тус үндэслэн Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь**:

1. Говь ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Ц.Баатарсайханыг 3 (гурван) жилийн хугацаатайгаар сонгон томилсугай.
2. Шинээр томилогдсон Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /Ц.Баатарсайхан/-д ТУЗ-ийн үйл ажиллагааг холбогдох хууль, дүрэм, журамд нийцүүлэн чиглүүлж, компанийн засаглалын тогтолцоог бэхжүүлэн, тасралтгүй сайжруулж ажиллахыг үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ГИШҮҮД:



Б.АМАРСАЙХАН

Ц.БААТАРСАЙХАН

Д.ГЭРЭЛМАА

А.ЖАРГАЛМАА

Б.ОРГИЛ

Ц.ОРГИЛБОЛД

Д.ХУЛАН

Д.ХҮРЭЛБААТАР

Б.ЦЭЭНЯМ



2025 он 05 сар 14 өдөр

Дугаар 20

Улаанбаатар хот

ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнийг шинэчлэн томилох тухай

Говь ХК-ийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орсонтой холбоотой ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнийг шинэчлэн томилох асуудлыг хэлэлцсэний үндсэн дээр Монгол Улсын Компанийн тухай хуулийн 81-р зүйлийн 81.1, 81.2 дахь заалт, Компанийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.2.20, 6.2.21 дэх заалтыг тус тус үндэслэн Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнийг Хавсралт-1 ёсоор шинэчлэн томилсугай.
2. Шинээр томилогдсон хороодын дарга, гишүүдэд Компанийн тухай хууль, Говь ХК-ийн дүрэм болон ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагааны журамд заасан чиг үүргийг хэрэгжүүлж, ажиллахыг үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ГИШҮҮД:



Б.АМАРСАЙХАН

Ц.БААТАРСАЙХАН

Д.ГЭРЭЛМАА

А.ЖАРГАЛМАА

Б.ОРГИЛ


Ц.ОРГИЛБОЛД

Д.ХУЛАН

Д.ХҮРЭЛБААТАР

Б.ЦЭЭНЯМ

Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2025 оны 05-р сарын 14-ний өдрийн хурлын
20-р тогтоолын 1-р хавсралт



ГОВЬ ХК-ИЙН ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООДЫН БҮРЭЛДЭХҮҮН

Хороод		Бүрэлдэхүүн	
Нэр дэвшүүлэх хороо	дарга	хараат бус гишүүн	Д.Гэрэлмаа
	гишүүн	хараат бус гишүүн	Д.Хүрэлбаатар
	гишүүн	ердийн гишүүн	Д.Хулан
Цалин урамшууллын хороо	дарга	хараат бус гишүүн	Д.Хүрэлбаатар
	гишүүн	хараат бус гишүүн	А.Жаргалмаа
	гишүүн	ердийн гишүүн	Б.Оргил
Эрсдэл, аудитын хороо	дарга	хараат бус гишүүн	А.Жаргалмаа
	гишүүн	хараат бус гишүүн	Д.Гэрэлмаа
	гишүүн	ердийн гишүүн	Б.Цээням



2025 он 05 сар 14 өдөр

Дугаар 21

Улаанбаатар хот

**Ноос, ноолуур, арьс ширний боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих
эргэлтийн хөрөнгийн ногоон зээлийн гэрээ байгуулах тухай**

“Говь” ХК нь “ХААН” банкттай зээлийн гэрээ байгуулах тухай асуудлыг хэлэлцсэний үндсэн дээр, Монгол Улсын Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1, 76 дугаар зүйлийн 76.1.17, 76.1.18, 89 дүгээр зүйлийн 89.1, 92 дугаар зүйлийн 92.1 дэх заалтыг тус тус удирдлага болгон “Говь” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь**:

1. “Говь” ХК нь дараах нөхцөлийн дагуу “ХААН” банкттай “Ноос, ноолуур, арьс ширний боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих эргэлтийн хөрөнгийн ногоон зээл” авах гэрээ байгуулахыг зөвшөөрсүгэй. Үүнд:
 - 1.1. Зээлийн хэмжээ: 6,000,000,000 /зургаан тэрбум/ төгрөг;
 - 1.2. Зээлийн хугацаа: 24 /хорин дөрвөн/ сар;
 - 1.3. Зээлийн хүү: Төгрөгийн зээлийн хүү жилийн 16.0 /арван зургаан/ хувь, Засгийн газраас хариуцан төлөх зээлийн хүүгийн хөнгөлөлт нь жилийн хувьсах 10.0 /арван/ хувь.
2. Дээрх хэлцэл нь сонирхлын зөрчилтэй хэлцэлд тооцогдох тул Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдийн дийлэнх олонхын саналаар шийдвэрлэн баталсугай.
3. Зээлийн гэрээ, бусад холбогдох гэрээ, бичиг баримтад “Говь” ХК-ийг төлөөлж гарын үсэг зурах эрхийг “Таван Богд Холдингс” ХХК-ийн Санхүү удирдлага хариуцсан захирлын үүрэг гүйцэтгэгч /Б.Оргил/-д олгосугай.

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД:



Д.ГЭРЭЛМАА

А.ЖАРГАЛМАА

Д.ХҮРЭЛБААТАР